



ДУНДГОВЬ АЙМГИЙН САЙНЦАГААН СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2021 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 19

Мандалговь

Хяналтын хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн 22.1.5, Монгол Улсын Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалын 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь :

1. Орон нутгийн хөгжлийн сангаас хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр арга хэмжээний ажлын үр дүнд хяналт тавьж, үнэлгээ хийх Хяналтын хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга : Ж.Мөнхтөр (ИТХ-ын тэргүүлэгч)

Нарийн бичгийн дарга : Н.Эрдэнэбат (ИТХ-ын төлөөлөгч)

Гишүүн : А.Отгонбаатар (ИТХ-ын тэргүүлэгч)

Б.Эрдэнэбулган (ИТХ-ын төлөөлөгч)

Э.Энхтөр (ИТХ-ын төлөөлөгч)

О.Сэрээтэр (ИТХ-ын төлөөлөгч)

Б.Энхтувшин (ТА-3 төслийн зохицуулагч)

2. Хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний ажилд явц болон төгсгөлийн хяналт шалгалт хийж, үнэлгээ өгч, үр дүнг ИТХуралд тайлагнаж ажиллахыг Хяналтын хорооны дарга (Ж.Мөнхтөр)-д даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 36 тоот тогтоолыг хүчингүйд тооцсугай.



ДАРГА

Т.БАТЖАРГАЛ